



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/157

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдсэн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн орон нутаг дахь төсөл хэрэгжүүлэх багийн ажилчдын хөдөлмөрийн хөлсөнд зориулан 36 213 120 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 36 213 120 төгрөг /гучин зургаан сая хоёр зуун арван гурван мянга нэг зуун хорь/-ийг аймгийн байгаль хамгаалах сангийн 2.1-д тусгагдсан “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бодлого зорилтыг хэрэгжүүлэх” арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/157 Ch

02 0931

Аймгийн Засаг даргын 2021 оны  
03 дугаар сарын 26-ны өдрийн  
А/157 дугаар захирамжийн хавсралт

**“БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ” ТЭСЛИЙН ОРОН НУТАГ ДАХЬ  
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАГИЙН АЖИЛЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН  
ХӨЛСНИЙ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ**

№	Үйл ажиллагаа	Хугацаа /сар/	Нэгж үнэ /төг/	Нийт дүн /мян.төг/
1	Аймгийн төсөл хэрэгжүүлэх багийн ажилтан Ч.Мөнгөнхүүгийн хөдөлмөрийн хөлс	12	1 005 920	12 071 040
2	Аймгийн төсөл хэрэгжүүлэх багийн ажилтан Д.Одончимэгийн хөдөлмөрийн хөлс	12	1 005 920	12 071 040
3	Аймгийн төсөл хэрэгжүүлэх багийн ажилтан Э.Удвалын хөдөлмөрийн хөлс	12	1 005 920	12 071 040
	Нийт			36 213 120

-oOo-